- ТӨБЗГ-ын 2020 оны 131 дүгээр тогтоолоор Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 86,513.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Тоёота Ланд Крузер-200 маркийн автомашиныг балансаас балансад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2020 оны А-1/1766 дугаар албан бичгээр анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй 44,162.6 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалан үндсэн хөрөнгийн данс буурсан үзүүлэлттэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,238,097.3 мянган төгрөг болж, 4,809,086.2 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсөвт нийт 4,780,578.4 мянган төгрөг төвлөрүүлж, санхүүгийн үр дүнгийн тайланд нөлөөлснөөс шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,702,751.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт 246,746.0 мянган төгрөгөөр буюу ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлаас 185,245.2 мянга, байр

ашиглалтын үйлчилгээний зардлаас 48,800.4 мянга, бусад зардлаас 12,700.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 5,456,005.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Дээд шатны байгууллагад хүргүүлсэн төсвийн төслийн саналаас 246,746.0 мянган төгрөгийг бууруулж баталсан, мөн төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 122,660.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь төсвийн төлөвлөлтийг бодитой боловсруулаагүй байгааг харуулж байна.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,146,999.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 5,024,338.3 мянган төгрөгийг зарцуулж, 122,660.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,024,338.3 мянган төгрөг буюу 95.4 хувьтай байгаа нь тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 79,481.0 мянган төгрөгөөр 3 албан хаагчийн тэтгэвэрт гарах хугацаа хойшлогдсонтой холбоотой дутуу зарцуулалт үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл "Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ"-д орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 768,359.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн, мөн улсын төсөвт тээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ 171,099.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү
Улсын тэмдэгтийн хураамж	-	768,359.4	(768,359.4)
Гэрчилгээний үнэ	-	171,099.6	(171,099.6)
Нийт дүн		939,459.0	(939,459.0)

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Хөрөнгө гаргах тухай" №150 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас Монгол Улсын ерөнхийлөгчийн БНХАУ-д айлчлал хийхэд үүссэн онцгой үүргийн нислэгийн зардал 97,757.0 мянга, Монгол Улс дахь Нэгдсэн үндэстний байгууллагын санхүүжилтээр "Жолооч танд" төслийн эхний шатны санхүүжилт 4,035.0 мянга, нийт 101,792.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 81, хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 24 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,106,777.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад улсын төсөвт төвлөрүүлж, хэрэгжүүлэн ажилласан байна. Аудитаар өгсөн 11,192.4 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай үнэлэгдсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт /аудитын явцад/	1	1,106,777.2	1	1,106,777.2	1	1,106,777.2	100
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	3	11,192.4	2	9,323.3	1	1,869.1	83.3
Нийт дүн	4	1,117,969.6	4	1,117,969.6	4	1,117,969.6	91.6

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,954,655.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,746,567.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 208,088.8 мянган төгрөгийн зөрчлөөс 2 зөрчилд 189,759.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, цаашид давтан гаргахгүй байх 18,329.6 мянган төгрөгийн 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 15,064.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,990.7 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүнд тусгаагүй;
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлого 4,035.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасныг;
3. Цалингийн өглөг дансанд хасах дүнтэй 1,878.8 мянган төгрөгийн гүйлгээ бүртгэснийг;
4. Гэрээт ажлын урьдчилгаа санхүүжилт 4,035.0 мянга, 2021 оны хэвлэл захиалгын 366.1 мянга, чатпот үйлчилгээний гэрээний урьдчилгаа 330.0 мянган төгрөгийг тус тус тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрснийг;
5. Дотоод албан томилолтын зардлын тооцоо 5,545.8 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй орлогоор бүртгэж, зарцуулсныг;
6. Үндсэн хөрөнгийн шинжтэй 5 төрлийн 4,614.2 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэснийг;
7. ТӨБЗГ-ын 2020 оны А-1/995 дугаар албан бичгээр шилжиж ирсэн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 1,123.6 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг;
8. Кассын тайлангийн орлого, зарлагын гүйлгээг 3,782.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг;
9. Able болон санхүүгийн 5,142.0 мянган төгрөгийн программыг биет бус хөрөнгөнд бүртгээгүй байсныг;
10. Антивирусын 6,167.0 мянган төгрөгийн үнэ бүхий программыг бараа материалын тайланд бүртгэлгүй, зардалд шууд тусгасныг;
11. Бичиг хэрэг, засвар ариутгал хангамж зэрэг 20,512.6 мянган төгрөгийн бараа материалыг тайланд тусгалгүй шууд зардалд, 9,805.0 мянган төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр бүртгэснийг;

12. Бараа материалын үлдэгдэлд биет тест хэрэгжүүлж үзэхэд 10 нэр төрлийн 40,704.4 мянган төгрөгийн бараа материал, үнэт цаасны бүртгэлийг дутуу хөтөлсөн байсныг;
13. Мөнгөн кассын ажиллагааны журам зөрчиж, их хэмжээний буюу 308,292.8 мянган төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээг касс бэлнээр байршуулан зарцуулсныг;
14. “Монголын үнэт цаас хэвлэл” ХХК-тай урьд онд байгуулсан ТХГ2019-09-16 өдрийн 201901001 дүгээр гэрээний гэрчилгээний үлдэгдэл 9,790.6 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэлгүй, тайлант хугацааны зардлаар бүртгэсэн байсныг тус тус санхүүгийн тайланд залруулав.
15. Улсын тэмдэгтийн хураамжийн Худалдаа хөгжлийн банкин дахь 2600074943 дугаар улсын тэмдэгтийн хураамж төвлөрүүлдэг “Тэг үлдэгдэлтэй” дансны 2019, 2020 оны үлдэгдэл нийт 1,305,464.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байсныг Үндэсний аудитын газрын 2021 оны “Төлбөр барагдуулах тухай” 02/A0170067 дугаар актыг үндэслэн аудитын явцад аудитын хяналт шалгалтын орлогын дансанд төвлөрүүлсэн;
16. Улсын комисст хүлээлгэж өгсөн Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км, Цахир-Тосонцэнгэлийн чиглэлийн 127.1 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км, Баянхонгор-Байдрагийн чиглэлийн 129.4 км авто замын техникийн хяналтын зардлаас хэмнэгдсэн 345,919.3 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байсныг Үндэсний аудитын газрын 2021 оны “Төлбөр барагдуулах тухай” 01/A0170067 дугаар актыг үндэслэн аудитын явцад аудитын хяналт шалгалтын орлогын дансанд төвлөрүүлсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 208,088.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 189,759.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 90 дүгээр магадлалаар албан тушаалд эгүүлэн томилогдсон С.Дорждагвад ажилгүй байсан хугацааны 30,311.3 мянган төгрөгийн цалинг цалингийн сангаас олгоходоо буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т *“Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”*, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэж заасантай тус тус нийцэхгүй, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг зөрчин улирал бүрийн үр дүнгийн урамшууллаас гадна жилийн эцсийн урамшууллыг 124 албан хаагчдад 159,447.9 мянган төгрөгийн, мөн бусад шагнал, урамшууллыг хавтгайруулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т *“өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т *“Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна”* гэж заасантай тус тус нийцэхгүй, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 18,329.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Зам, тээврийн яамны Худалдаа хөгжлийн банкин дахь улсын тэмдэгтийн хураамжийн орлого төвлөрүүлэх 2600074943 тоот "Тэг үлдэгдэлтэй данс"-ыг Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн 2013 оны 24/24/А-9 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, банканд нээх, хаах журам"-ын дагуу гурвалсан гэрээ байгуулаагүй, арилжааны банкны үлдэгдлийг тайлант хугацаанд тухай бүр төвлөрүүлэлгүй 2 жил дамжуулсан, санхүүгийн тайланд тусгадаггүй зэрэг асуудал нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улсын тэмдэгтийн хураамж төвлөрүүлэх Худалдаа хөгжлийн банкин дахь 2600074943 тоот "Тэг үлдэгдэлтэй данс"-ыг холбогдох журмын дагуу гурвалсан гэрээ байгуулж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.3-д "хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх бусад орлого", Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4-т "Энэ хуульд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн хугацааг сунгахад хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тухай бүрд нь ... хураахаар заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамжийг хураана", Засгийн газрын болон төсөвт байгууллагын дансыг Монгол банк, банканд нээх, хаах журмын 4.4-т "Тэг үлдэгдэлтэй данс нээлгэх хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд улсын төсвийн орлогын дансны талаар тухайн орлогыг бүрдүүлэгч байгууллага, банк, Сангийн яамны хооронд ... төлбөр тооцоог зохицуулах гурвалсан гэрээг байгуулна..." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Улсын тэмдэгтийн хураамжийн орлого тухай бүр төвлөрөхгүй байх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох журмын дагуу арилжааны банктай гурвалсан гэрээ байгуулж, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг тухай бүр төвлөрүүлж байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Урсгал санхүүжилтийн данснаас босго үнэ давсан төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээний зардалд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд "худалдан авах ажиллагааны журмыг сонгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ажиллах;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,000.0 мянган төгрөгийн шатахуун, мэдээлэл технологийн зардлаас 4,293.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 4,418.4 мянган төгрөгийн утасны төлбөр, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 8,618.2 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал тус тус худалдан авч зардлыг ангилал зөрчиж зарцуулсан нь Төсвийн

тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2014 оны 55, 2018 он 134 дүгээр тушаалд заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах;

3.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

4. Анхан шатны баримттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Албан томилолттой холбоотой анхан шатны баримтын бүрдэлд шатахуун зарцуулалтад жолоочийн замын хуудасгүй, тооцоо хийж баримтжуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.2 Эрсдэл:

Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ бүртгэх;

4.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэх;

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

5. Шилэн дансны ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 81, хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 24 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

5.2 Эрсдэл:

Төсвийн үйл ажиллагааны ил тод байдлын зарчим алдагдах;

5.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021 он			САГ-2021/352/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Зам, тээврийн хөгжлийн яамны аппарат		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 90 дүгээр магадлалаар албан тушаалд эгүүлэн томилогдсон С.Дорждагвад ажилгүй байсан хугацааны 30,311.3 мянган төгрөгийн цалинг цалингийн сангаас олгохдоо буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй.	30,311.3	Албан шаардлага хүргүүлсэн	ЗТХЯ-ТНБД Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл О.Очгэрэл
2	Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг зөрчин улирал бүрийн үр дүнгийн урамшууллаас гадна жилийн эцсийн урамшууллыг 124 албан хаагчид 159,447.9 мянган төгрөгийн, мөн бусад шагнал, урамшууллыг хавтгайруулан олгосон.	159,447.9	Албан шаардлага хүргүүлсэн	ЗТХЯ-ТНБД Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл О.Очгэрэл
3	Улсын тэмдэгтийн хураамж төвлөрүүлэх Худалдаа хөгжлийн банкин дахь 2600074943 тоот "Тэг үлдэгдэлтэй данс"-ыг холбогдох журмын дагуу гурвалсан гэрээ байгуулж ажиллаагүй.	-	Зөвлөмж өгсөн	ЗТХЯ-ТНБД Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл О.Очгэрэл
4	Урсгал санхүүжилтийн данснаас босго үнэ давсан төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээний зардалд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллаагүй.	-	Зөвлөмж өгсөн	ЗТХЯ-ТНБД ХОУХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч	С.Батболд Ч.Ренчиндамба Г.Алтангэрэл О.Очгэрэл
5	Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,000.0 мянган төгрөгийн шатахуун, мэдээлэл технологийн зардлаас 4,293.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 4,418.4 мянган төгрөгийн утасны төлбөр, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 8,618.2 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал тус тус худалдан авч зардлыг ангилал зөрчиж зарцуулсан байна.	18,329.6	Зөвлөмж өгсөн	ЗТХЯ-ТНБД Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл О.Очгэрэл
6	Албан томилолттой холбоотой анхан шатны баримтын бүрдэлд шатахуун зарцуулалтын жолоочийн замын хуудасгүй, тооцоо хийж баримтжуулаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	ЗТХЯ-ТНБД Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч	С.Батболд Г.Алтангэрэл О.Очгэрэл
7	Тайлант хугацаанд оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 81, хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 24 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн	ЗТХЯ-ТНБД ХОУХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодогч	С.Батболд Ч.Ренчиндамба Г.Алтангэрэл О.Очгэрэл
ДҮН		208,088.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 23

№ 05/А0170067

Улаанбаатар хот

САГ - 2021/352/СТА-ПЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 90 дүгээр магадлалаар албан тушаалд эгүүлэн томилогдсон С.Дорждагвад ажилгүй байсан хугацааны 30,311,265.00 /гучин сая гурван зуун арван нэгэн мянга хоёр зуун жаран таван/ төгрөгийн цалинг цалингийн сангаас олгохдоо буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ч.Ренчиндамба нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0223\auditin_2-R_Gazar3.Docx

001080977



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 23

№ 06/АД170067

Улаанбаатар хот

САТ-2021/352/СТА-743

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг зөрчин улирал бүрийн үр дүнгийн урамшууллаас гадна жилийн эцсийн урамшууллыг 124 албан хаагчдад 159,447.9 мянган төгрөгийн, мөн бусад шагнал, урамшууллыг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Засгийн газрын тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах, Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 107 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын холбогдох заалтыг бусад хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardiaga\2021\0223auditin 2-R Газар4.Docx


001080980

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ч.Ренчиндамба нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 03 № 02/АО170067
САГ-2021/352/СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: Зам, тээврийн хөгжлийн яамны Худалдаа хөгжлийн банкин дахь 2600074943 дугаар улсын тэмдэгтийн хураамж төвлөрүүлдэг "Тэг үлдэгдэлтэй" дансны 2019, 2020 оны үлдэгдэл нийт 1,305,464,658.00 /нэг тэрбум гурван зуун таван сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга зургаан зуун тавин найман/ төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Тэг үлдэгдэлтэй" дансны үлдэгдэл 1,305,464,658.00 төгрөгийг /нэг тэрбум гурван зуун таван сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга зургаан зуун тавин найман/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ч.Ренчиндамба нарт даалгасугай.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 23

№ 01/A0170067

Улаанбаатар хот

САГ-2021/352/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зам, тээврийн хөгжлийн яамны аппаратын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын комисст хүлээлгэж өгсөн Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км, Цахир-Тосонцэнгэлийн чиглэлийн 127.1 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км, Баянхонгор-Байдрагийн чиглэлийн 129.4 км авто замын техникийн хяналтын зардлаас хэмнэгдсэн 345,919,328.00 /гурван зуун дөчин таван сая есөн зуун арван есөн мянга гурван зуун хорин найман/ төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.26-д "техник, технологийн хяналт" гэж авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Техник хяналтын зарцуулагдаагүй үлдэгдэл 345,919,328.00 /гурван зуун дөчин таван сая есөн зуун арван есөн мянга гурван зуун хорин найман/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ч.Ренчиндамба нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР



Д.БОЛОР-ЭРДЭНЭ

